

АНУ-ЫН ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР БАЙГУУЛАХ БОДЛОГО, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Э.Батзориг*

АНУ-ын ЧХХ нь хөрөнгө оруулагчын эрх ямбыг хадгалах, хүрээлэн буй орчныг хамгаалах, ажилчны болон оюуны өмчийн эрхийн баталгаар бий болгох, үйлчилгээний салбарыг чөлөөлөх зэрэг “найрсаг” стандартыг тогтоох замаар өөрийн хэрэгцээг хангахын сацуу бусад орнуудын нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлогод бодит өөрчлөлт оруулах, түүнчлэн чингэх эрх зүйн үндэслэлийг гаргах гэсэн хамгийн энгийн мөртөө алсыг харсан, боломжит бодлогын хэрэгсэл болоод байна. 2007 оны байдлаар АНУ - Австрали, Бахрейн, Израиль, Йордан, Марокко, Оман, Сингапур, Чили гэсэн орнуудтай ЧХХ хэлэлцээр байгуулаад байгаа бөгөөд ойрын хугацаанд буюу эсвэл тодорхой болзол хугацааны дотор Колумб, Перу, Индонез, Мозамбик, Өмнөд Солонгос, Тайланд болон бусад нэр бүхий дурдсан орнуудтай ЧХХ байгуулахаар зорьж байна. Дэлхийн түүхэнд ноёрхлоо бодитой тогтоож асан их гүрнүүдийн сүүл мушгигч гэсэн тодотгол зүүх хувьдаа АНУ өнөөдөр ч гэсэн өөрийн байр суурийг улам бүр бэхжүүлсээр байна. Түүх сөхөн нотлобоос: аугаа удирдагчдийн нууц хуйвалдааны үл ойлголцлоос үүдэн гарахдаа зүйрлэшгүй хохирол авчирсан дэлхийн II дайны дараа Нэгдсэн Холбоо байгуулах замаар балгас болсон европыг дахин сэргээх, нөгөө талаас иймэрхүү төрлийн дайн дахин гарах боломжийг хаах, түүнээс урьдчилан сэргийлэх үзэл санаа хүчтэй газар авч байлаа. Хөрөнгө мөнгөгүйн улмаас бодож сэтгэхээс цаашгүй байсан энэ үеийг АНУ ирээдүйд өөрт үр дүнгээ өгөхөөр ашиглаж улмаар бодит үр дүн болгосон нь хожмоо Маршаллын төлөвлөгөө гэж түүхнээ нэрлэгдсэн дайны уршгаар ядарч сульдсан эдийн засагтай, түүхий эдийн нөөцгүй болсон Европт туслах тухай төрийн нарийн бичгийн дарга Жорж Маршаллын санаа байлаа.¹ Ийнхүү Жорж Маршаллын санаа хэрэгжиж Европ тив хөл дээрээ боссон боловч АНУ-ын дэлхийн хэмжээнд үзүүлэх жин нөлөө урьд хожид байгаагүйгээс ихэссэн гэж дүгнэх боломжтой. Ялангуяа дэлхийн II дайн АНУ тэргүүтэй өрнөдийн холбоотны үнэмлэхүй ялалтаар өндөрлөсөн тэр үеэс АНУ-ын худалдаа, эдийн засгийн ашиг сонирхол дэлхийн хэмжээнийх болж эхэлсэн бөгөөд энэхүү давуу байдлаа ашиглаж ТХЕХ-ийн 9 цуврал үе шат болон ДХБ-ын хэлэлцээрийг ажил хэрэг болгоход “бодлогын тоглогч”-ын хувиар оролцсоор ирсэн. Хамгийн анх 1985 онд Израильтай, дараа нь 1994 онд Мексик, Канадтай хамтран ХАЧХХ²-ийг байгуулсан. Улмаар энэхүү ХАЧХХ-ийн тэлэлт болгож 1994

* Э.Батзориг -ГХЯ-ны Гэрээ, Эрх зүйн газрын мэргэжилтэн

Энэхүү өгүүлэлд орсон санал, үнэлэлт дүгнэлт нь судлаачийн хувийн байр суурь бөгөөд тус яамны албан ёсны байр суурь биш болохыг анхаарна уу.

оны 12 сарын 11-нд АНУ-ын санаачлагаар Баруун Хагас дахь Бөмбөрцгийн хөгжиж байгаа орнуудтай тодорхой зөвшилцөлд хүрсний үр дүнд Маяамид болсон Дээд хэмжээний уулзалтын үеэр АТЧХБ байгуулах хэлэлцээр эхлүүлсэн байна.³ ЧХХ байгуулж эхэлсэн үеэс болон хожим, тодруулж хэлбэл жинхэнэ утгаар 1999 онд АНУ-ын Сиатл хотноо хуралдсан ДХБ-ын Сайд нарын ээлжит III хурал бүтэлгүйтсэн үеэс АНУ-ын өөрийн стратегийг өөрчилж “гурвалсан сувгийн хандлага”-аар хоёр болон бус нутаг, түүнчлэн олон талт хэлэлцээр байгуулах замаар өөрийн хүчинд дулдуйдах их гүрний эдийн засгийн неолибераль хандлагаар хэлэлцээр⁴ байгуулах болсон бол 2001 оны 9 сарын 11-ний алан хядах ажиллагаа гарснаас хойш түүнээс сэргийлэх АНУ-ын цэргийн ажиллагааг дэмжсэн орнуудад олгох шагнал буюу нэг ёсондоо гадаад бодлогын хэрэгсэл⁵ (favoratism) болсон байна. ЧХХ-ийг тойрсон шүүмжлэлийг тунгаан үзвээс, ЧХХ байгуулах явдлыг ДХБ-ын хэлэлцээний хүрээнд няцаах гэсэн нэг хэсэг байхад зөвхөн АНУ-ын хуулийн этгээдийн ашиг сонирхол дээр тулгуурлаж түншүүдтэй хэлэлцээ хийх гэсэн нөгөө бүлэг этгээд байна. Аль ч талаас харсан томоохон этгээдүүдтэй хэлэлцээ хийхэд юун түрүүнд ДХБ-ын хэлэлцээрийн үзэл санааг иш үндэс болгох хэрэгтэй бөгөөд чухамхүү түүний дараа л АНУ-ын худалдаа, хөрөнгө оруулалтын бодит ашиг сонирхлыг хамгаалсан ЧХХ байгуулах тухай ярих нь зөв байж болох юм. Гэхдээ бодит байдал дээр гадаад болон эдийн засгийн бодлогын хүрээнд хөндөх асуудал харилцан адилгүй хэмжээнд тавигдах ба зарим нь тохирч, мөн зарим нь харшилдах байх. Шалгуур үзүүлэлтийн тэргүүлэх чиглэлийг түнш болох гэж буй тэдгээр орнуудад тэгш хүртээмжтэй байдлаар тогтоох нь бараг л боломжгүй. Нөгөө талаас ЧХХ байгуулах талаар гаргаж байгаа АНУ-ын саналууд нь нөгөө л том гүрний байр суурин дээр үндэслэгдсэн байдгаас хэлэлцээр байгуулах тэгш зарчим алдагдаж байгаа тал ажиглагдаж байна. Сингапур зэрэг орнуудыг зах зээлийн нээхдээ төрийн мэдлийн чухал компаниудыг хувьчлах, санхүүгийн эрх бүхий байгууллагаас хөрөнгийн талаар хяналт тавих явдлыг болиулах зэрэг болзлыг тулган хүлээлгэх байдлаар гаргаж тавьж байгаа нь шударга бус байдал буйг гэрчилнэ.⁶

АНУ-ын одоогийн хандлага нь хэд хэдэн давуу талтай. Дотоод бодлогыг олон улсаас гарч буй санаачлагатай холбох, түүнчлэн худалдаа болон бусад гадаад бодлогод нөлөө үзүүлэхүйц дотоодын хүчирхэг дэмжлэгийг тогтоох нь эхний давуу тал мөн. Худалдааны дипломат ажиллагаа, гадаад бодлого хоёрыг гүнзгийрүүлэх, гадаад эдийн засгийн ололт нь АНУ-ын улс төрийн ашиг сонирхлыг (ардчиллыг цогцлоох гэх мэт) бэхжүүлэх бөгөөд улс төрийн холбоотон нь худалдаа, хөрөнгө оруулалтын эргэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлдэг гэдгийг хүлээн зөвшөөрдөг нь удаах давуу тал болно.

Сул талын хувьд, худалдаа, гадаад бодлогын ашиг сонирхлоос улбаалсан давуу талд АНУ-ын засгийн газраас хэрэгжүүлж буй харалган бодлого хамгийн их гай тарьж байна. Геополитикийн болон худалдааны ашиг сонирхлын холбоо бүхий бодлого тодорхойлогч болох хувьдаа АНУ-ын ХТГ⁷ тийм ч тодорхой бөгөөд магадгүй тогтвортой байж чадахгүй үйл ажиллагаа явуулж байна. Хоёрдугаарт, байгуулж буй ЧХХ-үүдээр аж үйлдвэрийн болон хөдөө аж ахуйн гаралтай барааны гарал үүслийн өөр хоорондоо ялгаатай журам тогтоож байна. Иймд АНУ-ын хэлэлцээ хийх эрх бүхий этгээдүүд нь Дохагийн хөтөлбөрт тусгагдсан аж үйлдвэрийн тарифыг арилгах буюу тухайлбал, ЧХХ-үүд дэх гарал үүслийн ялгавартай хандах журмын өртгийг багасгах зэрэгт санаачлага гаргах шаардлагатай юм. Гуравдугаарт, одоо хэрэгжиж буй стратеги нь тус тусын бүс нутагт улс төр, эдийн засгийн илэрхийлэл болж чадахгүй “жижиг гар”-ын улс (тухайлбал энд Хойд Африкаас Марокко, Персийн Булангаас Бахрейн, Өмнөд Азиас Шри-ланк гэх мэт улс орно)-уудтай холбогдож байна. Батлагдсан хөтөлбөрийн дагуу эдгээр улсын заримтай хэлэлцээр байгуулаад буй боловч тэдгээр нь хэзээ ч улс төр, эдийн засгийн ашиг өгч чадахгүй.⁸ Нэмж хэлэхэд тиймэрхүү жижиг орнуудтай хэлэлцээр хийх нь АНУ-ын худалдааны эрх бүхий этгээдүүдийн анхаарлыг ДХБ болон бусад томоохон ач холбогдол бүхий ЧХХ байгуулах явдлаас хөндийрүүлэх зэрэг муу үр дагавартай гэсэн шүүмж багагүй гарч байна. Конгрессийн 2002 онд баталсан Худалдааны Акт⁹-аар худалдааны зорилтуудыг өргөн хүрээнд тодорхойлсон боловч АНУ-ын ХТГ “урд хормойгоо, хойд хормойгоороо нөхсөн” төсвөөр үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ нь бас л АНУ-ын бодлогын зорилтууд өөр хоорондоо зөрчилдөж байгаагийн илрэл болно. Зарцуулах ёстой төсвийн хэмжээ хангалтгүй байгаа тул АНУ-ын ХТГ ЧХХ-ийн тэргүүлэх чиглэлийг дахин тогтоох шаардлагатай болж байна. Хэрэв АНУ өөрийн гадаад болон эдийн засгийн бодлогын ашиг сонирхлыг хангах үүднээс хэд хэдэн бүс нутгийн хэмжээнд өөрийн нөлөөллийг тогтоохыг хүсвэл ЧХХ-ийг гагцхүү томоохон эдийн засаг бүхий орнуудтай байгуулах талаар хэлэлцээ өрнүүлэх учиртай.¹⁰ Өөрөөр хэлбэл, хэдий чинээ том эдийн засагтай хамтарч ажиллана, АНУ-ын эдийн засаг төдий чинээ ашигтай байна гэсэн үг. Учир иймээс Турк болон Өмнөд Солонгосын зах зээлд экспорт, хөрөнгө оруулалтын сонирхол бүхий компаниуд эдгээр улстай хэлэлцээ хийхийг дэмжиж байна. Гэсэн хэдий ч АНУ-ын орлогын багагүй хэсэг АНУ-ын худалдааны саад болон татаасыг бууруулсан болон бас ч гэж зүй зохистой эдийн засгийн “тохируулга” хийсэн зэрэг хүчин зүйлээс бүрдэж байгааг дурдах хэрэгтэй. Иймэрхүү хэлбэрийн ЧХХ байгуулснаар, тус тусын зах зээл дээр томоохон өрсөлдөөнтэй тулгарах магадлалтай тул АНУ-ын импортын өрсөлдөөнд суурилсан үйлдвэр болон ферм (ялангуяа төмөр, оёмол сүлжмэл бүтээгдэхүүн, бэлэн хувцас гэх мэт)-үүдийн зүгээс хүчтэй эсэргүүцэл гарна.

Гэхдээ л “том” ЧХХ нь бодит ялагдагчдаас том дэмжлэг авах ч өсөн нэмэгдэх өрсөлдөөнт цохигдсон ялагдагсадаас мөн хэмжээний эсэргүүцэлтэй тулах нь зүйн хэрэг. Улс төрийн хандлагаас үзвэл, томоохон эдийн засагтай холбоо тогтооно гэвэл тэр нь эргээд ЧХХ-ийн түнш сонгох тооцоололтой зөрчилдөөн үүсгэнэ. Бүс нутгийн хэмжээнд тулгарч буй аливаа асуудлыг шийдвэрлэх нийтлэг хандлагыг тогтооход хэрэглэгдэх улс төрийн бодит ашиг тусыг бий болгоход худалдааны сайн харилцаа (Хойд Солонгос гэх мэт) тустай. Гэвч нөгөө талаас, АНУ-ын аль нэг түнш орон улс төрийн холбоотон болох хувьдаа худалдааны бодлоготой холбогдуулан ямар нэгэн “жич” зүйл хүсч болзошгүй бөгөөд хэрэв ингэвэл тэр нь зөвхөн эдийн засгийн хүчирхэг орнуудтай хэлэлцээр байгуулах хэтийн төлөвтэй харшилдаж бас болох юм.¹¹

Иймд, нэгдүгээрт, АНУ-ын эрх бүхий этгээд нь худалдааны хэлэлцээ хийхүйц эдийн засгийн томоохон түншийг хайх бөгөөд ингэхдээ ДХБ-ын асуудлыг тэргүүлэх чиглэлдээ багтаах ёстой. Тиймэрхүү хэлэлцээ хийхэд учирч буй хүндрэл байгаа хэдий ч АНУ ДХБ-ын үйл явцыг урагшлуулах, түүнчлэн дэлхийн худалдааны шинэчлэлийг гүнзгийрүүлэх байдлаар ЧХХ байгуулах ёстой. Хоёрдугаарт, АНУ-ын эрх бүхий этгээдүүд нь олон талт тогтолцооны зүй тогтлыг алдагдуулахгүйгээр эдийн засаг, гадаад бодлогын хүрээнд ашиг гаргахуйц байдлаар тооцож ЧХХ-ийн түншээ сонгох ёстой.

Бразил, Өмнөд Солонгосыг эс тооцвол АНУ-тай эдийн засгийн харилцааг өргөн хүрээнд тогтоож, түүнтэй ЧХХ байгуулах гэсэн орнуудын байдал буюу тухайлбал, онцлог төрхийн болон үйлчилгээний худалдаа, гадаадын шууд хөрөнгө оруулалт болон хөгжлийн туслалцаа зэргээрээ “боломж”-ийн гэсэн үнэлгээ авах орон бараг алга. Дээрхи орнууд тус тусын бүс нутагт улс төрийн тогтвортой байдлыг хангахад чухал нөлөөлөл үзүүлж байна. Тэдэнтэй хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээний шинэчлэлийн зэрэг өргөн хүрээний асуудал хамарсан ЧХХ байгуулсан тохиолдолд бодлогын томоохон маргаан гарч болох боловч эдийн засаг, улс төрийн үр өгөөж нь бодитой байх боломжтой. АНУ Солонгостой ЧХХ байгуулснаар Зүүн Азид өдрөөс өдөрт улс төр, эдийн засгийн нөлөөлөл нь хүчээ авч байгаа Хятадын “жанжлах” бодлогыг сөрөх боломж бодитой бүрэлдэхийг зарим шинжээчид тооцоолж байна.¹² Учир нь Хятад улс Солонгосын худалдааны хоёр дахь том түнш орон төдийгүй ЗӨАҮХ, ЗӨАҮХ+З зэрэг АНУ оролцогч биш бүс нутгийн эдийн засгийн тогтолцоонд өөрийн “ашиг сонирхол”-ыг бий болгох тал дээр багагүй амжилт гаргаад байгаа. Нөгөө талаар хэрэв АНУ-Солонгосын ЧХХ байгуулагдсан тохиолдолд энэ нь Япон зэрэг томоохон улсыг иймэрхүү төрлийн хэлэлцээрийг АНУ-тай байгуулахаас өөр замгүй болгох нэг ёсны “албадлага”-ын хэрэгсэл байж болох юм.

Өмнөд Солонгостой хийж буй АНУ-ын худалдаа нь урьд хожид байгуулагдсан буюу цаашид байгуулагдах гэж буй ЧХХ-ийн түнш орнуудаас

үлэмж их юм. Хэрэв АНУ-Солонгосын хооронд ЧХХ байгуулагдсан тохиолдолд тэр нь ХАЧХХ-ээс хойш байгуулагдсан хамгийн том ЧХХ болох юм.¹³ 2002 оны байдлаар¹⁴ хоёр орны бараа, үйлчилгээний худалдааны эргэлт нийт 68 тэрбум ам.доллар болсон байна. Байгуулах ЧХХ-тээ хөдөө аж ахуйн асуудлыг тусгах юм бол хоёр орны эдийн засагт ихээхэн ашиг өгөх төлөвтэй. Мөн хэлэлцээр байгуулснаар өдрөөс өдөрт хурцдаж буй Солонгосын Хойг дахь улс төр, аюулгүй байдлын харилцааг сайжруулах боломжтой.¹⁵ Гэхдээ дээрхи хоёр орны албаны этгээдүүд ЧХХ байгуулах талаар багагүй эргэлзэж байна. Өмнөд Солонгосын оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн, бэлэн хувцас болон ган эдлэлийн экспортод урт удаан хугацааны туршид тавигдсаар ирсэн АНУ-ын саад тотгорыг арилгах нь тэртэй тэргүй Хятадын нийлүүлэгчдийн өрсөлдөөнөөс болж багагүй “хохирол” амсч буй дотоодын үйлдвэрлэгчдийн хувьд мөн л хүндээр тусна. ЧХХ-ээр урамшуулал хийсэн шинэчлэл нь Солонгосын фермерийн аж ахуй эрхлэгчдийн зүгээс хүчтэй эсэргүүдэл дагуулж магадгүй. 2003 онд ерөнхийлөгч Ро, хэрэв хэлэлцээрээр хөдөө аж ахуйн шинэчлэл хийхийг шаардсан тохиолдолд АНУ-тай ЧХХ байгуулахгүй гэх утгатай мэдэгдэл хийсэн. Шинэчлэлийн талаар баримтлах энэхүү тууштай үзлээс болж АНУ-ын тал Өмнөд Солонгостой ЧХХ байгуулах тал дээр нэг их хүч гаргахгүй байна. Гэсэн хэдий ч Зүүн Ази дахь худалдаа улам бүр боловсронгуй болж буй явдал нь Өмнөд Солонгосыг ЧХХ дэх хөдөө аж ахуйн бодлогоо уян хатан болгохоос өөр аргагүй болгож байна. Ялангуяа, Солонгос-Японы хооронд байгуулагдах хэлэлцээр нь экспортлогч этгээдүүд нь Зүүн Хойд Азийн зах зээлд ялгавартай зарчимтай “тулах” орнуудын зүгээс худалдааны санаачлага гаргах шаардлагыг бий болгох нь гарцаагүй. Үнэхээр ч Зүүн Азийн өрсөлдөөнийг чөлөөлсөн тохиолдолд Японтой харилцах түвшингээ тодорхойлох гэсэн АНУ тэргүүтэй орнууд барьцах нь мэдээж. Солонгосын худалдааны томоохон түнш болох Хятад улс ч гэсэн үүнийг дагах болно. Хоёр орны хувьд, хөдөө аж ахуй нь тэдний шаардлагын төв чиглэл нь болж байна. Нэмж хэлэхэд, дэлхийн худалдааны томоохон оролцогчид болох Солонгос, Япон зэрэг орнууд нь өөрсдийн фермерийн аж ахуйн худалдааны саад тотгорыг багасгасан тохиолдолд Дохагийн үе шатны хүрээнд цаашид хэрэгжих хэлэлцээ амжилттай болно. Худалдааны хэлэлцээ хийгч нар нь хөдөө аж ахуйн талаархи ДХБ-ын асуудалд хаалт хийсээр байсан үед Солонгосын экспортлогчид өндөр үнэ төлсөөр байх нь гарцаагүй. Солонгос улс өөрийн фермерийн аж ахуй эрхлэгчдэд худалдааны хамгааллаас орлогын дэмжлэг үзүүлэх хүртэл замаар фермерийн аж ахуйн шинэчлэлийн талаар баримтлаж буй бодлогоо өөрчлөх ёстой. Хөдөө аж ахуйн нийтлэг бодлогын шинэчлэлийг хангахад Европын Холбоо яг ийм бодлого баримтладаг. Дурдсан энэхүү дэмжлэгийг хэдий гүйцэд биш ч бодит импортын саад тотгорын шинэчлэлтэй хослууснаар Солонгосын эдийн засгийн өсөлтөд багагүй түлхэц өгнө.

Бразил мөн Солонгосоос дутуугүй чухал сорилт боломжийг гаргаж байна. 2002 оны статистикаас¹⁶ үзэхэд хоёр орны худалдааны нийт эргэлт худалдааны хязгаарлалт, татварын дарамт болон худалдаа, хөрөнгө оруулалтыг “өдөөхүйц” бодлого үгүйгээс болж АНУ-Бразилийн хооронд ЧХХ байгуулах явдал санаа төдийхнөөс хэтрэхгүй байна.¹⁷ Шилдэг загваруудаас хийсэн судалгаанаас үзэхэд, хоёр талын ЧХХ байгуулснаар худалдааны эргэлт хоёр дахин өсч, АНУ-Бразилийн онцлог төрхийн худалдааны хэмжээ АНУ-Өмнөд Солонгосын худалдааны хэмжээтэй тэнцэх тооцоо гарч байна. Өмнөд Солонгосын хувьд бол худалдааны саад тотторыг арилгадаггүй юм гэхэд бууруулах ёстой. Энэ нь элсэн чихэр, этилийн спирт, цитрус, ган зэрэг бүтээгдэхүүнээр дамжуулан АНУ-ын зах зээлд нэвтрэх боломжийг Бразилд олгох хэрэгтэй гэсэн үг. Бразил дотоодын элдэв шаардлагыг багасгаж, эдийн засгийн өсөлтийг хангах тал дээр анхаарах ёстой. ЧХХ байгуулснаар худалдаа, эдийн засгийн бодлогын шинэчлэлийг хийхэд чиглэсэн дотоодын оролдлогод түлхэц болдог. Бразилийн шинэ засгийн газар дотооддоо алдарт “Бразил зардал”, гадаадад өөрийн экспортлогчдод учрах саад тотторыг багасгах үүднээс протекционист дарамтыг өргөн хэрэглэж байгаа нь өөрийн орны эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх юм.

Иммануэль Валлерштайны дэлхийн тогтолцооны онолын шалгуураар үзвэл Бразил дэлхийн хэмжээний томоохон тоглогч болох хэв шинж рүүгээ дөхөж яваа¹⁸ тул АНУ-ын хувьд, Бразилтай ойр дотно харилцах нь олон арван жилийн турш бүс нутгийн хэмжээнд эдийн засгийн хөгжлийг хангах, ардчиллын үйл явцыг бэхжүүлэхэд чиглэн явуулж буй хүчин чармайлтад түлхэц үзүүлнэ. Худалдаа, хөрөнгө оруулалт өргөжин тэлэх нь хоёр оронд орлогыг нэмэгдүүлж, ажилгүйдлийг багасгах, улс төрийн хамтын ажиллагаа, соёлын солилцоо явагдах шинэ сувгийг нээх болон бөмбөрцгийн интеграцчилалыг бэхжүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ.¹⁹ Иймээс Америк тивийн Чөлөөт Худалдааны Бүс болон ДХБ-ын хэлэлцээний явцыг идэвхижүүлэхийн тулд АНУ-Бразилийн худалдааны харилцааны өөр бусад гарцыг талууд бодолцох ёстой. Өмнөд Солонгос, Бразил хоёр АНУ-тай ЧХХ байгуулахад бэлэн үү? Ямар ч байсан эдгээр улсууд нь худалдаатай холбоотой цогц шинэчлэл хийхэд бэлэн буйгаа илэрхийлсэн. Мөн дотоодын эсэргүүцэл тодорхой, АНУ-ын зах зээлд нэвтэрснээр олох ашгийн хэмжээ тодорхой бус байна. Гэвч хоёр орон эдийн засгийн хөгжлийн ололтод хүрэхийг хүсвэл ойрын хугацаанд дурдсан бэрхшээлээс гарах ёстой. АНУ-ын санаачлага ч гэсэн шинэчлэлийг дэмжих ёстой. Өмнөд Солонгос, Бразил зэрэг улстай хэлэлцээр байгуулснаар АНУ-ын ЧХХ-ийн бодлогод “бодлогын эргэлт” гарах болно. АНУ-ын түншүүд АНУ-ын худалдааны саад тотгорын тодорхой шинэчлэлийн хариу болгож чөлөөт худалдааны цогц тохиролцоог хүлээн авсан тохиолдолд нэр бүхий хоёр улс АНУ-тай ЧХХ байгуулах магадлал ихэснэ. Хоёр улс АНУ-ын эрх баригчдыг улс төрийн хувьд

хүндхэн шийдвэр гаргахыг тулгах боловч үүний хариуд АНУ-ын фирм, ажилчин болон фермерийн аж ахуй эрхлэгчдэд эдийн засгийн бодит урамшуулал олгох юм. Мөн улсууд нь тус тусын фермерийн аж ахуйн бодлогын шинэчлэлийг гүнзгийрүүлснээр бүс нутгийн болон олон талт хэлэлцээний үйл явцад нааштай “почроо” өгөх болно. Ингэснээр дээрхи хоёр улс АНУ-тай ЧХХ байгуулах гэсэн урт дарааллын эхний байрт жагсах боломжийг олж авна.²⁰ АНУ харин бэлэн үү? Урьд 2002 онд Дохагийн уулзалтын үеэр тус улс аж үйлдвэрийн тариф болон экспортын татаасыг арилгах буюу мөн фермерийн дотоодын дэмжлэгийг багасгах тал дээр үүрэг хүлээсэн. Гэвч хэрэв иймэрхүү өөрчлөлтийг АНУ хийсэн тохиолдолд татаас болон бусад төрлийн худалдааны хамгаалалаа алдах аюулыг эсэргүүцэх “сөрөг хүчин”-ий асуудлыг эдийн засгийн болон гадаад бодлогын түвшинд авч үзэх шаардлагатай болно.²¹ Учир иймээс АНУ-ын эрх баригчид том сэтгэх, мөн хэмжээний ЧХХ-ийг худалдааны стратегийн нэгээхэн хэсэг болгож байж энэхүү нөхцөл байдалд амжилт гаргах буюу дэлхийн худалдааны шинэчлэлийг хангахад түлхэц үзүүлэх хүч болж чадна.

ЧХХ байгуулах түнш орныг сонгох шалгуур, түүний хэрэгжилт, хэрэгжилтийн явц

АНУ-тай ЧХХ байгуулах гэсэн орнууд дотоод гадаад олон зүйлээр өөр хоорондоо харилцан адилгүй байх нь мэдээж. Энд тухайлбал, эдийн засгийн багтаамжаас эхлээд газар зүйн байршил хүртэл олон зүйл хамаарна. Иймд Конгрессийн олон гишүүн гүйцэтгэх засаглалын эрх бүхий этгээдийг аливаа улстай ЧХХ байгуулахдаа өөрийн орны тэргүүлэх амин чухал ашиг сонирхлыг эн тэргүүнд тавьсан тодорхой шалгуур боловсруулан мөрдөхийг санал болгосоор иржээ.²² ЧХХ байгуулах түнш сонгохдоо юун түрүүнд хөгжиж байгаа орнуудтай тогтоосон харилцааг чухалчлах бөгөөд удаах байрт АНУ-ын улс төр, эдийн засаг, аюулгүй байдлын ашиг сонирхол тухайн орнуудад хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох хэрэгтэй. Эдийн засгийн ашиг сонирхлын үүднээс түнш сонгох гэдэг нь өргөжин тэлж байгаа зах зээлд нэвтрэн орох боломжийг нэмэгдүүлэх, АНУ-ын ажилчин, фермерийн аж ахуй эрхлэгчдийн гадаадын нийлүүлэгчидтэй өрсөлдөх “талбарын түвшин”-г тогтоох буюу ДХБ-ын хэлэлцээр дэх АНУ-ын зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх холбоотныг эрэлхийлэх замаар АНУ-ын худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх явдал юм. Гадаад бодлогын агуулгаар бол энэ нь чөлөөт худалдаа эрхлэх замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, эрх зүйт төр, ардчилсан засаглалын тулгуурыг бэхжүүлэх, алан хядах явдлын эсрэг тэмцэлд дэлхий нийтийн дэмжлэгийг хүлээх явдал мөн.²³ Гадаад харилцаанд чиглэсэн иймэрхүү “стратегийн” онолын түвшинд чухал хэдий ч бодит байдал дээр АНУ өөрийн гадаад

бодлого дахь худалдааны асуудалд хэр зэрэг тэргүүлэх ач холбогдол өгөх нь бүрхэг байна. Тодруулах нь:

Нэгдүгээрт, даяарчлалыг гүнзгийрүүлэх хүрээнд үндэстэн хоорондын эдийн засгийн таталшлыг бэхжүүлэх нь гадаад харилцааны салшгүй чухал бүрдэл хэсэг мөн. Эдийн засгийн тусламж болон хориг нь сайн харилцааг хөхиүлэн дэмжих буюу эсвэл гадны засгийн газруудаас “зай барих” хэрэгсэл болсон. Хенри Киссенжирийнхээр бол худалдаа нь хэдий чинээ өргөжинө, улсуудын харилцаа хамаарал төдий чинээ бэхжих боловч нөгөө талаас тэр нь эргээд улс бүрт бодлогын зорилтын зөрчилдөөний “уурхай” болж болох талтай. Улс төрийн болон аюулгүй байдлын ашиг сонирхол худалдааны бодлого дээр төвлөрөх үү? Хүйтэн дайны үед бол магад тийм гэх байсан биз. Тэгээд ч хүйтэн дайн дууссанаас хойш эдийн засгийн ашиг сонирхол тэргүүлэх байрт явах болсон. Гэсэн хэдий ч худалдааны ихэр цамхагт халдсан үйл явдлын дараа худалдааны бодлогын санаачлага болон аюулгүй байдлын хоорондын харьцаа мэдэгдэхүйц зузаарсан бөгөөд магадгүй аюулгүй байдлын ашиг сонирхол нэгдүгээрт тавигдах болсон.²⁴

Хоёрдугаарт, гүйцэтгэх засаглалын агентлагуудын зохицуулалт харилцан адилгүй гардаг. Төр, батлан хамгаалах, худалдаа, сангийн эрх бүхий этгээдүүд болон ХТГ-аас гаргаж буй шийдвэр, журмууд нь Конгресс болон Цагаан Ордноос гарч буй тогтоолуудтай зөрчилддөг. Конгрессийн зарим гишүүд болон бизнесийн нэгдлүүдийн үзэж байгаагаар²⁵ гадаад, дотоод худалдаа нь ямар нэгэн хаалтгүйгээр явагдаж байх ёстой байхад бусад гишүүд хүний эрх зөрчдөг, цөмийн зэвсэг дэлгэрүүлэх ажиллагаанд гар бие оролцдог, хар тамхи болон терроризмыг дэмждэг орнуудтай санхүүгийн туслалцаа үзүүлэх буюу худалдаа, хөрөнгө оруулалтын харилцаа тогтоохыг хориглосон хууль санаачилж байна. Өөр хоорондоо харшилдсан дээрхи байдлаас болж АНУ-ын худалдааны нэгдсэн стратеги батлахад хүндрэл учирч байгаа тул хэрэвзээ зохистой шийдэл олохыг хүсвэл АНУ-ын эрх баригчид Конгресс ба дотоодын лобби бүлгийн, өөрийн гадаад түншүүдтэйгээ буюу гадаад гэсэн 2 түвшинд хэлэлцээ хийж нэгдмэл байр суурьт хүрэх шаардлагатай.²⁶ 2003 оны 5 сард “ЧХХ ба АНУ-ын худалдааны бодлого” сэдвийн дор болсон бага хурлын үеэр Худалдааны Төлөөлөгч Роберт Золлик²⁷, АНУ худалдааны хэлэлцээр байгуулах түншээ сонгохдоо дор хаяж 13 хүчин зүйлийг бодож үзэх шаардлагатайг тайлбарлажээ. 2004 онд АНУ-ын Санхүүгийн Ерөнхий албанаас ЧХХ байгуулах түншийг нэр бүхий 6 шалгуураар оруулах ёстойг тогтоосон.²⁸ Тэгвэл шинжээч Жеффри Скот дээрхи хүчин зүйлүүдийг нэгтгэн үзэж улмаар тэдгээрийг үндсэн 4 хэсэгт ангиж болох тухай санал гаргасан. Эдгээрт:²⁹ 1) АНУ-ын дотоодын бодлогод ямархуу нөлөө үзүүлэхийг тогтоосон үнэлгээ; 2) Эдийн засгийн зорилт тодорхойлогдсон байдал; 3) Худалдааны шинэчлэлийн талаар түнш этгээдийн хүлээх үүргийн хэмжээ; 4) Гадаад бодлогын асуудал.

Дотоод бодлого. Бушийн засаг захиргааны ЧХХ байгуулах гол үндэслэл нь 2002 онд батлагдсан Худалдааны Акт юм. Шинээр ЧХХ байгуулах нь Конгрессийн гишүүд болон хувийн хэвшлийн сонирхлын бүлэг хоорондын худалдааны санаачлага гаргахад дэмжлэг болж чадах эсэх асуудалд эхний шалгуур төвлөрнө. Дараах 3 хүчин зүйлс өгүүлэн буй процессийг явуулах хөшүүрэг болно.³⁰ 1) Улс төр, эдийн засгийн агуулгаар ЧХХ-ийн түнш этгээдэд тусламж үзүүлэхийг гишүүд сайшаах эсэх? 2) Худалдааг либералчлах талаархи хэлэлцээг уян хатан аргаар явуулж болох эсэх? 3) Бизнес эрхлэгч, фермерийн аж ахуй эрхлэгч болон иргэний нийгэм дэх худалдааны хэлэлцээр байгуулахад эргэлзэгч хэсэг бүлэг хүмүүст итгэл үнэмшил түрүүлэхүйц нотолгоог ЧХХ дэх заалт бий болгож чадах эсэх? Мөн энэ хүрээнд АНУ-ын эрх баригчид, ЧХХ байгуулах нь АНУ-ын бусад улсад үзүүлэх нөлөөллийг мэдэгдэхүйц байдлаар тогтоох гэсэн ашиг сонирхлыг хангах чухал хэрэгсэл мөн гэдгийг Ардчилсан намынханд итгүүлэх, Бүгд Найрамдахчуудын зүгээс худалдааны хамгааллын бодлогыг бэхжүүлэх оролдлогыг лавшруулах гэсэн нэр бүхий хоёр асуудлыг шийдвэрлэх ёстой.

Эдийн засгийн бодлогын асуудал. Дараах шалгуурт АНУ-ын “уламжлалт”-эдийн засгийн ашиг сонирхлыг хангах тухай асуудал хамаарна. ЧХХ-ийн түнш орныг сонгон шалгаруулахад дараах асуулт тавигдана.³¹ 1) ЧХХ нь түнш орны нутаг дэвсгэр дээр АНУ-ын хөрөнгө оруулагчдын ашиг сонирхлыг хамгаалах буюу экспортын хэмжээг нэмэгдүүлэх боломжийг бий болгох уу? 2) Энэхүү хэлэлцээрийг байгуулснаар, сонгон шалгаруулалтад улс оролцогч нь болох өөр ЧХХ-ийн дагуу бусад гадаадын нийлүүлэгчдийн ашиг хүртэж буй хөнгөлөлтийн дэглэмийг тэнцвэржүүлэх замаар АНУ-ын экспортлогчын оролцооны түвшинг тодорхойлж чадах уу? 3) Үйлчилгээ, оюуны өмч, хөдөлмөр, хүрээлэн буй орчны салбарт хожим байгуулагдах бүс нутгийн болон хоёр талын аливаа хэлэлцээрт жишиг тогтоож чадах уу? Дүгнэхэд, эдийн засгийн агуулгаар бол АНУ-ын эрх баригчид ЧХХ-ийг өөрийн орны пүүс, ажилчин болон фермерүүдэд экспортын шинэ боломжийг нээж өгөх зорилгоор ашиглаж байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд ХАЧХБ нь бүс нутгийн худалдаа, хөрөнгө оруулалтын өсөлтийн загвар болж байна. Канад, Мексик болон бусад орнуудтай худалдаа хийснээр АНУ-ын худалдааны эргэлт 2 дахин өссөн мэдээ байна.³² АНУ-тай ЧХХ байгуулахаар сонгон шалгаруулалтад орж байгаа этгээдийн ихэнхи нь хөгжиж буй жижиг эдийн засагтай орнууд байна. Томоохон эдийн засаг бүхий орнуудтай худалдаа эрхлэх нь мэдээж их хэмжээний ашиг өгнө. Гэхдээ аль ч тохиолдолд АНУ нь хөдөө аж ахуй, оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн болон бэлэн хувцас зэрэг импортын барааны мэдрэмтгий салбаруудыг хамгаалж буй саад тотгорыг

аль болох либералчлах талаар өөрөөс шалтгаалах бүх арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй болов уу.

Түнш орнуудын хүлээх үүрэг. АНУ-ын эрх баригчдын үзэж буйгаар тэдний байгуулаад буй ЧХХ нь бүхий л асуудлыг хамран зохицуулагч “төрийн урлаг”, ДХБ-ын эргэн тойронд тодорхой үүрэг бий болгох хэрэгсэл болж байна.³³ Үүний дүнгээр үзвэл ЧХХ нь АНУ-ын худалдааны түншүүдийн дотоодын болон худалдааны зохицуулалтын практикийг шинэчлэх гол хэрэгсэл юм. ДХБ болон хоёр талт хэмжээнд боловсрогдож буй тэрхүү “шинэ зохицол”-д оролцохын тулд улс орнууд өргөтгөсөн шинэчлэлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх хэрэгтэй. ЧХХ байгуулах түнш сонгох тухай энэхүү гурав дахь шалгуур нь хоёр талт худалдааны хэлэлцээрт тусгасан нөхцөл шаардлагатай нийцүүлэн өөрсдийн бодлогыг өөрчлөх чадвар, хүсэл зориг бий эсэх, мөн ДХБ-ын хэлэлцээр дэх дор дурдсан асуудалд бодит, нааштай үр дүн гаргахад АНУ-ын хэлэлцээрт оролцогч нартай гар нийлж ажиллах боломж байгаа эсэхийг тодорхойлоход хэрэглэгдэнэ.³⁴ Үүнд: 1) Түнш орон өөрийн дотоод эдийн засгийн шинэчлэлийн хөтөлбөрийг батлаж, түүнийгээ ажил хэрэг болгох, түүнчлэн эдийн засгийн интеграцчилалыг гүнзгийрүүлэхэд өөрийн хөрш орнуудтайгаа хэрхэн зохицож, үүрэг амлалтаа биелүүлж байгаа эсэхийг тогтоох, 2) Нийтлэг зорилгыг тодорхойлох буюу тэдгээрийг ДХБ-ын хэлэлцээрийн үзэл санаатай уялдуулах замаар хөхиүлэн дэмжихэд АНУ-тай хэрхэн гар нийлэх тухай зэрэг асуудал орно. Үнэн хэрэгтээ мөнхүү шалгуур нь улс орнууд өөрсдийн дотоодын зах зээлийг бодит “өрсөлдөөнт орчин” болгоход бэлэн байгааг тодорхойлно. Ерөнхийдөө “гэрийн даалгавар”-аа сайн биелүүлэх нь тухайн улс олон талт болон хоёр талын ЧХХ байгуулахад нэн тустай. ЧХХ байгуулах ихэнхи (Австралиас бусад) нэр дэвшигч орнууд хөгжиж буй орнууд байх тул тэдгээрийн макро эдийн засаг, худалдаа, татвар болон бусад бодлого зохицуулалтын шинэчлэлийг хангах чадвар болон улс төрийн үүргийг хууль ёсчлох ажиллагааг “жинхлэх” ёстой. Ихэнхи тохиолдолд иймэрхүү санаачлага нь тухайн орон хөрш орнуудын хамтаар бүс нутгийн хэмжээнд интеграцчилалыг гүнзгийрүүлэх санаачлагатай уялдаж байдаг. ЧХХ-ийн тусламжтайгаар өдрөөс өдөрт улам бүр нээлттэй болж буй худалдааны харилцаанд ашиг сонирхлыг нэгтгэх явдлыг хөхиүлэн дэмжихийг зорьж байх үест ЧХХ-ийн түнш орнууд дэлхийн худалдааны хэлэлцээг хөгжүүлэх зорилгоор өөрсдийн нийтлэг ашиг сонирхол бүхий салбарыг бий болгох ёстой. АНУ тэргүүтэй оролцогчид дэлхийн худалдааны харилцаанд зонхилох явдал саарч байгаа бөгөөд харин түүний оронд ДХБ-ын гишүүн 150 орны хооронд нэгдсэн зөвшилцөл тогтоохыг хөхиүлэн дэмжих зорилгоор эвсэл үүсгэхийг эрмэлзэх шаардлага урган гарч байна. Чухамхүү тэр дурдаад байгаа зөвшилийг

бий болгохын тулд “ижил сэтгэлгээ” бүхий орнууд ДХБ-ын дүрмийн дор ЧХХ байгуулах явдал нэмэгдэж байна.

Гадаад бодлогын асуудал. Олон улсын хэмжээнд үйлдвэрлэл явуулах болон худалдаа, гадаад бодлогынх нь ашиг сонирхол дэлхий дахиныг хамрахад нь дэмжлэг үзүүлсэн тохиолдолд тухайн улсыг шагнаан урамшуулах замаар АНУ-ын бодлогын хоёр томоохон зорилтыг хангах зэрэг асуудлыг энэхүү дөрөв дэх буюу эцсийн шалгуурт авч үзэж байна. Товчхондоо АНУ-ын ХТГ өөрийн шийдвэрийг гаргахдаа дараах 3 шалгуурыг харгалзан үзнэ.³⁵ Үүнд: 1) Тухайн улс гадаад бодлогын асуудлаар АНУ-тай гар нийлэн ажиллах эсэх 2) ЧХХ байгуулсан тохиолдолд тэр нь түнш орны эдийн засгийн хөгжлийг хангах буюу ардчилал, эрх зүйт төрийг бататгахад хөшүүрэг болж чадах эсэх 3) Нэр бүхий улстай хэлэлцээ хийх нь тив тус бүрээс гарах санаачлагын газар зүйн тэнцлийг барихад тус үзүүлэх эсэх.

Эхний шалгуурын агуулга туйлын энгийн. АНУ-ын Иракт явуулж буй ажиллагаанд гар бие оролцсоных нь төлөө Австрали улстай ЧХХ байгуулах асуудал мэдэгдэхүйц хэмжээнд хурдсаж, өнөөдөр бодит ашгаа хүртэн суугаа бол төвийг сахисан гэх үндэслэлээр³⁶ Шинэ Зеландын хэлэлцээр байгуулах процесс огцом мэдрэгдэхээ болив. Товчхондоо Иракт явуулж буй улс төр, цэргийн ажиллагаанд хэрхэн оролцож байгаа явдал нь нэр дэвшигч орнуудыг шалгаруулах “жинхэнэ” шалгуур болж байна. [KorUS FTA 2006: 10, URL] АНУ-тай ЧХХ байгуулахын тулд Бахрейн өөрийн бүс нутагт ардчиллын шинэчлэл, энх тайвныг хөхиүлэн дэмжих санаачлага гаргаж, түүнийгээ ажил хэрэг болгох үүрэг хүлээж байсан бол Египет улс эхэндээ овоо сайшаагдаж байсан бол дараа нь гаалийн болон эдийн засгийн бусад шинэчлэлийг хийхэд цалгардсан явдал хүсээд буй ЧХХ байгуулах асуудлын хугацааг хойш нь татаж багагүй гацаа үүсгэсэн нь тодорхой байна.³⁷ Удаах шалгуур нь өмнө дурдсанаар, дайны дараах Европ тивийг сэргээх тухай АНУ-ын Жорж Маршаллын бодлогын стандарттай уялдана. Хөгжингүй орнууд улс төрийн олон ургалч үзлийг сайшаах буюу ардчилсан засаглалыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг. Үүнийхээ хариуд эдгээр нэр бүхий улсууд нь АНУ-ын экспортлогчид болон хөрөнгө оруулагчдын хувьд тогтвортой зах зээл нь болох боломжтой юм.³⁸ Гуравдугаар буюу эцсийн шалгуур нь АНУ-ын бодлого тодорхойлогчдын хувьд нэг ёсны худалдаа болон харилцааг дэлхий дахинаа өргөжүүлэхийн дохио болох ёстой. ЧХХ гэгч нь олон талт хэлэлцээрээс өөрөөр дэлхий нийтийг хамарсан худалдааны ашиг сонирхлыг хангах хэрэгсэл мөн.³⁹

Уг нь АНУ дэлхийг хамарсан өөрийн худалдааны ашиг сонирхлыг бүс нутгийн хэмжээнд санаачлага гаргах замаар хангахыг хүсвэл худалдааны түншээр томоохон этгээдийг сонгох ёстой. Гэвч тэдгээр томоохон этгээдтэй байгуулах ЧХХ нь амьгүй (тэрхүү итгэл төрүүлээд байгаа түнш нь өөрийн худалдааг нээлттэй болгоход бэлэн биш) буюу хэрэгжих боломжгүй (ДХБ

дахь бодит нөлөөллөөс болж) байна. Дээр дурдсан 4 шалгуур нь АНУ-ын зүгээс хөгжиж буй орнуудтай харилцах гадаад болон эдийн засгийн бодлогын цогц байдлыг илэрхийлж байна. Худалдааны болон гадаад бодлогын нэгдлийг шүүмжлэх нэг хэсэг байхад, нөгөө талаас засгийн газрын хэлэлцээ хийх хязгаарлагдмал бололцоог хэрхэн ашиглах арга замыг тодорхойлоход эдийн засаг, улс төрийн хүчин зүйлийн тэргүүлэх чиглэл яг юу байхаас шалтгаалан дэмжлэг үзүүлэх эсэхээ шийдэх хэсэг этгээд бас байна. Эдгээр шалгуур хэрхэн хэрэгжиж буй болон АНУ яг зөв этгээдтэй ЧХХ байгуулж байна уу гэдэг дээр үзэл бодлын зөрүү байсаар байна. Зарим этгээд АНУ-ын бодлогыг хэт жижиг хэрэгт төвлөрөх буюу хэлэлцэж байгаа худалдааны асуудал нь явцуурч байгааг шүүмжлэх боллоо. Эдгээр шүүмж нь, эдийн засгийн томоохон хэлцэл хийх гэсэн, мөн АНУ-ын эрх баригчдын явуулж байгаа бодлого нь анхаарал тавих ёстой жинхэнэ асуудлыг ДХБ-ын хэлэлцээрийн хүрээнд үлдээчихээд өөрсдөө зөвхөн “жимс түүж” байна гэх хоёр хэсэгт хуваагдаж байна. Үүний хариу болгож АНУ-ын эрх баригчид, тэрхүү шүүмжлүүлдэд байгаа бодлого нь худалдааны шинэчлэл хийх боломжийг хадгалах буюу түүнчлэн бүс нутгийн болон олон талт санаачлагыг гаргахад түлхэц болох тухай дурджээ. Хоёр болон бүсийн, түүнчлэн олон талт түвшинд хэлэлцээг жигд байдлаар хөгжүүлэх нь нэр бүхий салбаруудыг либералчлах болон Дохагийн гацаа гэгдэх үйл ажиллагааны зогсонги байдлыг арилгахад тустай [Jeffrey, ed. 2004: 371, transl] Үнэн хэрэгтээ, АНУ-ын түнш буюу түнш болохоор “сонгон шалгаруулалт”-д орж буй орнуудын жагсаалтыг харахад сөрөгч болон хамгаалагч талуудын харилцан шүүмжид үнэний хувь байх вий. Үүнийг ЧХХ-ийн бодлого товлосон хугацаанд хэрхэн хэрэгжиж байсантай холбон үзье.

Нэгдүгээрт, АНУ-ын ЧХХ байгуулах санаачлага Бөмбөрцгийн Баруун Хагас тийш төвлөрсөн. Улс төр, эдийн засгийн агуулгаар нь үзвэл үүний хамгийн амжилттай жишээ нь одоо санаачлагын эцсийн шатандаа явагдаж буй ХАЧХБ юм. Аль ч өнцгөөс харсан өнөөдөр ч гэсэн ХАЧХБ нь Хойд Америкийн эдийн засгийн интеграцчилалыг гүнзгийрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байна.⁴⁰ Мөн хэдий байгуулагдаад олон жилийг өнгөрөөсөн ч тэрхүү хэлэлцээрийг боловсронгуй болгох нь АНУ-ын зүгээс авч хэрэгжүүлж буй бүс нутгийн чанартай томоохон санаачлагуудын нэг болж байна.

Хоёрдугаарт, ЧХХ байгуулахаар зорьж байгаа Латин Америкийн ихэнхи орнууд нь АТЧХБ-ийн хүрээнд хэлэлцээ хийж байгаа орнууд байх аж. Энэ нь нэг талаас бие даасан жижиг хэлцлүүд байж болох авч нөгөө талаас тэдгээр нь бүс нутгийн томоохон хэлэлцээрийн нэгээхэн хэсгүүд болж байна. Бразил, Аргентин, Парагвай, Уругвай, Венесуэль болон Карибын Сав газрын жижиг орнууд (АНУ-ын зах зээлд худалдааны хөнгөлөлт эдэлж байгаа) нь АТЧХБ-ийн гишүүн мөртөө АНУ-ын ЧХХ байгуулах орнуудын жагсаалтад ороогүй хэдхэн орон юм. Харамсалтай

нь Мексикийг оролцуулахгүйгээр, эдгээр орнууд нь Латин Америкийн дотоодын нийт бүтээгдэхүүний 50%-ийг бүрдүүлдэг. Латин Америкийн орнуудтай ЧХХ байгуулах замаар “Бразилийг бүслэх, АНУ-Бразилийн харилцааг идэвхижүүлэх, ингэснээр Бразилийг АНУ-тай ЧХХ байгуулахаас өөр аргагүй болгоход АНУ-ын стратеги чиглэгдэж байна.”⁴¹

Гуравдугаарт, худалдаа нь зарим ЧХХ дэх санаачлагад байх улс төрийн бодлогыг өргөжүүлэхэд тус дөхөм үзүүлнэ. Йордантай хийсэн хэлэлцээр нь Ойрхи Дорнодын орнуудтай цаашид хийх загвар болно.⁴² АНУ-аас гарч буй бүхий л санаачлага нь улс төрийн шинжтэй боловч өөрсдөд нь хэрэгтэй гэж үзэж байгаа бол сонгон шалгаруулалтад орж буй орнууд үг дуугүй зөвшөөрснөөр тэдний эдийн засгийн дотоод шинэчлэлд түлхэц үзүүлэхүйц ач холбогдол бүхий заалт агуулсан байх нь ажиглагдаж буйг шинжээчид дүгнэж байна.

Дөрөвдүгээрт, Австралитай хийж буй хоёр талт худалдааны нийт эргэлт нь АНУ-аас Колумб, Тайланд, Филиппин зэрэг орнуудтай хийх байгаа худалдаатай тэнцэж байна. Хоёр орны хооронд хийх хэлэлцээрээс үүдэн элсэн чихэр, сүү, сүүн бүтээгдэхүүн, үхэр болон хонины махтай холбоотой маргаантай асуудал гарах шинжтэй байсан боловч нэг талаас сонгуулийн жил тохиож буй болохоор үүнийг нь улс төрчид өөнтөглөхөөс болгоомжилж, нөгөө талаас АНУ-ын гадаад бодлогын санаачлагыг дэмжиж байгааг нь урамшуулах үүднээс тус улстай хийх ЧХХ-ийг тодорхой түргэвчилсэн хуваарийн дагуу байгуулж дуусгасан болно.

Эцэст нь, АНУ Тайландтай ЧХХ байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд хоёр орны худалдааны жилийн түвшин 2002 оны байдлаар⁴³ 20 орчим тэрбум ам.доллар болж байна. АНУ-тай ЧХХ байгуулах гэж буй ЗӨАҮХ-ны гишүүн орнууд бэлэн болсон, хэлэлцээртэй холбогдон гарах аливаа үүргийг биелүүлэх бололцоотой гэж үзвэл тэдгээр улстай байгуулах хэлэлцээрийн загвар нь АНУ-Сингапурын ЧХХ байх болно. Бэлтгэл ажил болгож ЗӨАҮХ-ны Санаачлагыг⁴⁴ дэмжиж, нөгөө талаас түүний гишүүн орнуудын хоорондын өрсөлдөөнийг либералчлах явцыг түргэсгэхэд түлхэц үзүүлж байна. Дүгнэн үзвэл АНУ-ын стратеги холимог шинжтэй бөгөөд түүнээс гарч буй дийлэнхи санаачлага нь Бөмбөрцгийн Баруун Хагас дахь нэгдлүүдтэй томоохон худалдааны хэлэлцээр байгуулахад оршиж байгаагаас гадна эдгээр санаачлага нь байгуулан буй ЧХХ-т тусгагдсан АНУ-ын улс төр, эдийн засгийн зорилтыг хангах болон ДХБ дахь ижил түвшний хэлэлцээг нөхөхөд чиглэгдэж байна. Нөгөө талаас мөн хэмжээний санаачлага дэлхийн жижиг орнуудтай эрсдэл багатай, ашиг багатай (улс төр, эдийн засгийн хосолмол агуулгатайгаар) хэлэлцээр байгуулахад чиглэгдэж байна.

Ашигласан материал

1. [Батзориг 2005: 165]
2. 1994 оны 1 сарын 1-нд байгуулагдсан Хойд Америкийн Чөлөөт Худалдааны Хэлэлцээрээр бүс нутгийн хамгийн том чөлөөт худалдааны бүсийг үүсгэсэн юм. Хүн амын тоо 410 сая, ДНБ 11 тэрбум ам.долларт хүрч байна. Энэхүү ЧХХ нь урьд 1989 оны 1 сарын 1-нд батлагдсан АНУ-Канадын хоёр талт хэлэлцээрийн загварт суурилсан болно.
3. [FTAA 2007: URL]
4. [KorUS FTA 2006: 7, URL]
5. [see in La Porta 2005: 60]
6. [KorUS FTA 2006: 8, URL]
7. АНУ-ын Худалдааны Төлөөлөгчийн газар нь АНУ-ын ерөнхийлөгчийн Гүйцэтгэх албанд харьяалагдаж, хоёр болон олон талт түвшинд АНУ-ын олон улсын худалдааны бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй гүйцэтгэх засаглалын хэрэгжүүлэгч байгууллага юм.
8. [Jeffrey, ed. 2004: 376, transl]
9. [Trade Act 2002: URL]
10. *ibid.*,
11. [Jeffrey, ed. 2004: 377, transl]
12. [KorUS FTA 2006: 9, URL]
13. *ibid.*,
14. [The World Almanac 2004: 314]
15. [Jeffrey, ed. 2004: 377, transl]
16. [The World Almanac 2004: 314]
17. [Jeffrey, ed. 2004: 378, transl]
18. [Brian Bahnisch 2004: URL]
19. *ibid.*,
20. *ibid.*,
21. *ibid.*,
22. *ibid.*,
23. *ibid.*,
24. [Evenett et. Al., 2006: URL]
25. [Jeffrey, ed. 2004: 364, transl]
26. [Evenett et. Al., 2006: URL]
27. АНУ-ын ерөнхийлөгч Жорж Бушийн томилгооны үндсэн дээр АНУ-ын ХТГ-ыг 2001-2005 оны хооронд толгойлж байсан. 2007 оны 5 дугаар сарын 30-нд ерөнхийлөгч Буш Пол Вульфовицын залгамжлагчаар түүнийг дэвшүүлсэн бөгөөд 2007 оны 6 дугаар сарын 25-нд Дэлхийн Банкны Гүйцэтгэх Зөвлөлөөс түүнийг баталсан.

28. [Markheim et. Al., 2006: URL]
29. [Jeffrey, ed. 2004: 365, transl]
30. *ibid.*,
31. *ibid.*,
32. [The World Almanac 2004: 315]
33. [Barfield 2007: URL]
34. *ibid.*,
35. *ibid.*,
36. [Evenett et. Al., 2006: URL]
37. *ibid.*,
38. *ibid.*,
39. *ibid.*,
40. *ibid.*,
41. *ibid.*,
42. [The World Almanac 2004: 314]
43. *ibid.*,
44. [Fact sheet on Free Trade and Thailand 2003: URL]